

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: “**КСН ангилуурын сэлбэг**” нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/202012336**

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос “КСН ангилуурын сэлбэг” нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байна.**

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилийн жилийн эцсийн тайлан, санхүүгийн тайлан, дүгнэлтийн хамт, нотариатаар баталгаажуулсан хуулбар хувь ирүүлнэ.**

Тендерийн хамт **1,815,000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 09:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:05 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98,
412 тоот өрөө, утас: 450060 + 188

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ